



2

0

2

5

IV

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ**  
2025 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот  
2025 он

## АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	1
1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	1
1.2. ХӨРВӨХ ЧАДВАР .....	2
1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД .....	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ .....	3
2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ .....	3
2.1.1. Хувьцааны арилжаа.....	4
2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа .....	5
2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа.....	5
2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа .....	6
2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ .....	7
2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц .....	7
2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	7
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД .....	9
3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид.....	11
3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан .....	12
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА .....	12
4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа.....	12
4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа .....	13
ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ .....	15
5.1. Эрх зүйн зохицуулалт .....	15
5.2.Хамтын ажиллагаа, арга хэмжээ.....	18
<i>Хавсралт 1. Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын         гүйлгээний үйлчилгээ үзүүлэгчдийн тайлан .....</i>	<i>22</i>


## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

### 1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2025 оны жилийн эцсийн байдлаар 13.88 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх улирлаас 5.25 хувиар, өмнөх оны мөн үеэс 6.58 хувиар тус тус өссөн үзүүлэлт бөгөөд уг үзүүлэлт нь 2024 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ний 17.21 хувьтай тэнцэж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Тайлбар: 2025 оны ДНБ гараагүй тул 2024 оны ДНБ-тэй харьцуулж тооцоолов.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 164 компаниас дараах 30 компанийн зах зээлийн үнэлгээ 13.09 их наяд төгрөгийн үнэлгээтэй байгаа нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 94.33 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани

№	Компанийн нэр	Эзлэх хувь	№	Компанийн нэр	Эзлэх хувь
1	“ХААН банк” ХК	19.01%	16	“Улсын Их Дэлгүүр” ХК	0.85%
2	“Тавантолгой” ХК	11.94%	17	“Монголын хөрөнгийн бирж” ХК	0.79%
3	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	9.04%	18	“Тутал” ХК	0.66%
4	“Голомтбанк” ХК	7.76%	19	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	0.58%
5	“АПУ” ХК	7.49%	20	“Эм Жи Эл Акуа” ХК	0.58%
6	“Хас банк” ХК	7.30%	21	“Монгол шуудан” ХК	0.56%
7	“Худалдаа хөгжлийн банк” ХК	7.01%	22	“Монложистикс холдинг” ХК	0.54%
8	“Инвескор ББСБ” ХК	4.91%	23	“Түмэн шувуут” ХК	0.53%
9	“Төрийн банк” ХК	2.67%	24	“Тандэм инвест ББСБ” ХК	0.48%
10	“Премиум нэксус” ХК	2.54%	25	“Тэнгэрдаатгал” ХК	0.38%


11	“МИК холдинг” ХК	2.53%	26	“Газар шим үйлдвэр” ХК	0.35%
12	“Сүү” ХК	1.54%	27	“Улаанбаатар бүк” ХК	0.32%
13	“Говь” ХК	1.26%	28	“Мандал даатгал” ХК	0.31%
14	“Лэндмн ББСБ” ХК	0.92%	29	“Инновэйшн инвестмент” ХК	0.31%
15	“Монгол даатгал” ХК	0.88%	30	“Ардкредит ББСБ” ХК	0.30%

Тайлбар: Зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.

## 1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар өмнөх улиралтай харьцуулахад 1.03 пунктээр өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.41 пунктээр буурч, 2.07 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2025 оны жилийн эцсийн байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 79.97 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

График 2. Хөрвөх чадвар (хувиар)



## 1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. ТОП-20 индексээр зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компанийн, MSE-A болон MSE-B индексээр үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьцааны үнийн индексийг тус тус харуулдаг байна.

Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

Индекс	2024	2025.III	2025	Өөрчлөлт /2025.III-2025/	Өөрчлөлт /2024-2025/
ТОП 20	51,296.39	49,327.20	54,478.17	10.44%	6.20%
MSE A	19,795.97	19,358.87	20,822.95	7.56%	5.19%
MSE B	15,197.38	14,493.08	14,361.75	-0.91%	-5.50%

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 55,019.79 нэгж, доод үзүүлэлт 46,334.87 нэгж, дундаж үзүүлэлт 50,137.87 нэгж байна. Өмнөх улиралтай харьцуулахад 5,150.97 нэгжээр буюу 10.44 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,181.78 нэгжээр буюу 6.20 хувиар тус тус өсөж, **54,478.17** нэгжид хүрсэн байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 21,103.44 нэгж, доод үзүүлэлт 16,889.29 нэгж, дундаж үзүүлэлт 18,727.44 нэгж байна. Өмнөх улиралтай харьцуулахад 1,464.08 нэгжээр буюу 7.56 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,026.98 нэгжээр буюу 5.19 хувиар тус тус өсөж, **20,822.95** нэгжид хүрсэн байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 15,868.99 нэгж, доод үзүүлэлт 13,935.41 нэгж, дундаж үзүүлэлт 14,690.29 нэгж байна. Өмнөх улиралтай харьцуулахад 131.33 нэгжээр буюу 0.91 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 835.63 нэгжээр буюу 5.50 хувиар тус тус өсөж, **14,361.75** нэгжид хүрсэн байна.


## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

### 2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт **1,315.46** тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 16.74 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд өдрийн дундаж арилжаа **5.33** тэрбум төгрөг байна. Нийт арилжааны 1.133.26 тэрбум төгрөгийн арилжаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар, 182.20 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар тус тус хийгдсэн байна.

Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 28.29 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 21.83 хувийг хувьцаа, 24.60 хувийг компанийн бонд, 14.29 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 10.99 хувийг Засгийн газрын үнэт цаас тус тус эзэлж байна.


График 3. Үнэт цаасны арилжааны хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)



### 2.1.1. Хувьцааны арилжаа

График 4. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд нийт 287.17 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19.86 хувиар буурсан, өмнөх улирлаас 98.20 хувиар өссөн үзүүлэлт юм.



Хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй, арилжааны хэмжээгээрээ тэргүүлэгч 30 компанийн арилжааны мэдээллийг үнийн дүнгээр харуулбал:

Хүснэгт 3. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөгөөр)

№	Компанийн нэр	Үнийн дүн	№	Компанийн нэр	Үнийн дүн
1	“Инвекор ББСБ” ХК	46.93	16	“Ардкредит ББСБ” ХК	2.91
2	“Голомтбанк” ХК	39.81	17	“Монложистикс холдинг” ХК	2.78
3	“ХААН банк” ХК	33.96	18	“Тэнгэрдаатгал” ХК	2.48
4	“Инновэйшн инвестмент” ХК	28.38	19	“Худалдаа хөгжлийн банк” ХК	2.21
5	“Премиум нэксус” ХК	23.07	20	“Түмэн шувуут” ХК	2.07
6	“Мандал даатгал” ХК	22.01	21	“Лэндмн ББСБ” ХК	2.05
7	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	10.31	22	“Тэнгэрлиг медиа групп” ХК	1.97
8	“АПУ” ХК	9.31	23	“Ард даатгал” ХК	1.65
9	“Эм Жи Эл Акуа” ХК	8.98	24	“Төрийн банк” ХК	1.63
10	“Монголын хөрөнгийн бирж” ХК	7.49	25	“Говь” ХК	1.28
11	“Хас банк” ХК	7.38	26	“Ремикон” ХК	0.94
12	“Тавантолгой” ХК	7.10	27	“Моносхүнс” ХК	0.88
13	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	5.61	28	“Сүү” ХК	0.84
14	“Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК	5.49	29	“Хоринхоёрдугаар бааз” ХК	0.82
15	“Дархан нэхий” ХК	3.20	30	“ОЛЛОО” ХК	0.55
<b>НИЙТ</b>					<b>284.07</b>

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Тайлант хугацаанд нийт 21 хувьцаат компанийн 501.49 сая ширхэг буюу 140.90 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 49.07 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Багцын арилжаа хийгдсэн компаниуд


№	Үнэт цаасны нэр	Арилжаалагдсан ширхэг (мянган ширхэг)	Үнийн дүн (тэрбум төгрөг)
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	688.36	1.89
2	“Ар Баянхангай” ХК	48.11	0.03
3	“Ард кредит ББСБ” ХК	18,819.23	1.84
4	“Хоринхоёрдугаар бааз” ХК	268.62	0.82
5	“Ард даатгал” ХК	1,625.74	1.14
6	“АПУ” ХК	3,507.58	3.99
7	“Барилга Корпораци” ХК	41.69	0.02
8	“Премиум нэксус” ХК	11,787.38	2.34
9	“Голомтбанк” ХК	20,800.00	26.73
10	“Инвескор ББСБ” ХК	1,268.33	10.59
11	“ХААН банк” ХК	3,024.04	3.64
12	“Эм Жи Эл Акуа” ХК	35,016.18	7.52
13	“Монложистикс холдинг” ХК	6,608.82	1.32
14	“Мандал даатгал” ХК	154,843.54	11.23
15	“Дархан нэхий” ХК	82,910.93	1.64
16	“ОЛЛОО” ХК	4,368.12	0.54
17	“Инновэйшн инвестмент” ХК	102,932.69	25.57
18	“Ремикон” ХК	16,000.00	0.77
19	“Худалдаа хөгжлийн банк” ХК	10.00	0.33
20	“Тэнгэрдаатгал” ХК	2,348.55	1.91
21	“Тэнгэрлиг медиа групп” ХК	329.75	1.93
<b>НИЙТ</b>		<b>501,491.57</b>	<b>140.904</b>

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК

### 2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

График 5. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаагаар 164.87 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 158.68 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.82 дахин буурсан, өмнөх улирлаас 64.79 хувиар өссөн үзүүлэлт юм.




### 2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 35 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаа бөгөөд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр 46 хувийн хөрөнгө оруулалтын сан, 8 хамтын хөрөнгө оруулалтын санг удирдаж байна.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо 5 компанийн хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн бөгөөд 4 хамтын хөрөнгө оруулалтын сангийн баримт бичгийг бүртгэж, 2 хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

График 6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа (тэрбум төгрөгөөр)




Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаагаар 2.14 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 185.89 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж өмнөх оны мөн үеэс 83.59 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 7. Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны задаргаа

Тайлант хугацаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн нийт 188.03 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс биржээр арилжаалагддаг хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангаар **5.83** тэрбум төгрөгийн арилжаа, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар **182.03** тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь тус тус нийт арилжааны 3.10 болон 96.90 хувийг бүрдүүлж байна. Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн арилжааны анхдагч зах зээлийн арилжаа 2.14 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлийн арилжаа 180.06 тэрбум төгрөг байна. Харин хоёрдогч зах зээлийн арилжааны 37.81 хувийг буюу **68.09**

тэрбумын арилжаа нь нэгж эрхээ эргүүлэн худалдан авах арилжаа байна.




- Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан
- Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан, ETF

#### 2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

График 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 171.00 тэрбум төгрөгийн арилжаа, хоёрдогч зах зээлд нийт 201.14 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, нийт 372.14 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 80.57 хувиар өссөн үзүүлэлт юм.




## 2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Тайлант хугацаанд **12,470** шинэ данс, **48,380** холболтын данс шинээр нээгдэж өссөн дүнгээр нийт **2,610,534** данс, **720,358** холболтын данс “ҮЦТХТ” ХХК-д бүртгэлтэй байна.

### 2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 9. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын биржийн арилжааны үнийн дүнд эзлэх хувь

Тайлант хугацаанд нийт хоёрдогч зах зээлийн арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 397.84 тэрбум төгрөг (55.73 хувь), дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 307.66 тэрбум төгрөг (43.10 хувь), гадаадын иргэний хийсэн арилжаа 3.36 тэрбум төгрөг (0.47 хувь), гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 4.96 тэрбум төгрөг (0.70 хувь)-ийг тус тус эзэлж нийт 490.09 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.



Эх сурвалж: "МҮЦКТ" ХХК, "Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх этгээдүүд

Дээрх арилжаанд давтагдсан тоогоор нийт 363,246 иргэн, 2,604 аж ахуйн нэгж оролцож, 3,666,778 удаагийн арилжаа хийсэн байна. (Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харна уу.)

Хүснэгт 5. Арилжаа эрхлэх байгууллагын хоёрдогч зах зээлийн арилжааны хөрөнгө оруулагчдын бүтэц

	Арилжаанд оролцогчийн тоо		Арилжаанд оролцсон тоо	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гадаадын ААН	142	0.04%	789	0.02%
Гадаадын иргэн	1,019	0.28%	3,303	0.09%
Дотоодын ААН	2,462	0.67%	15,590	0.43%
Дотоодын иргэн	362,227	99.01%	3,647,096	99.46%
<b>Нийт</b>	<b>365,850</b>	<b>100.00%</b>	<b>3,666,778</b>	<b>100.00%</b>

Эх сурвалж: "МҮЦКТ" ХХК, "Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх этгээдүүд


## 2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс буюу 2021 оны 09 дүгээр сараас 2025 оны жилийн эцэс хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд нийт 212 үнэт цаас гаргагчийн нийт 6.57 их наяд төгрөг, 262.92 сая ам.долларын үнийн дүн бүхий 430 өрийн хэрэгсэл 1,292 хөтөлбөртэйгээр бүртгэгдсэн бөгөөд 5.00 их наяд төгрөг, 181.37 сая ам.долларыг бодит татан төвлөрүүлсэн.

Үүнээс тайлант хугацаанд 125 компанийн нийт 2.39 их наяд төгрөг, 84.00 сая ам долларын үнийн дүн бүхий 150 өрийн хэрэгсэл 405 хөтөлбөртэйгээр бүртгэгдсэн бөгөөд 1.59 их наяд төгрөг, 63.89 сая ам.долларыг бодит татан төвлөрүүлсэн.


Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүртгэгдсэн үнийн дүн 27.79 хувиар өссөн, бодит татан төвлөрүүлсэн дүн 5.25 хувиар буурсан үзүүлэлт юм.

График 11. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн дүн болон бодит татан төвлөрүүлсэн дүн




Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал барилга, зам тээвэр 21.08 хувь, боловсрол, эрүүл мэнд 0.80 хувь, мэдээлэл, холбоо 0.10 хувь, банк бус санхүүгийн байгууллага 24.13 хувь, барьцаалан зээлдүүлэх газар 11.54 хувь, үнэт цаасны компани 0.02 хувь, хөрөнгө оруулалт 2.51 хувь, уул уурхай, олборлолт 16.31 хувь, үйлдвэрлэл 1.94 хувь, хөдөө аж ахуй 0.26 хувь, худалдаа, үйлчилгээ 5.41 хувь, эрчим хүч 15.22 хувь, бусад салбар 0.69 хувийг тус тус бүрдүүлж байна.

График 12. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар (хувиар)



2025 оны жилийн эцсийн байдлаар биржийн бус зах зээлд нийт 2.87 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх улирлаас 58.36 хувиар, өмнөх оны мөн үеэс 26.50 хувиар тус тус өссөн үзүүлэлт байна.

График 13. ББЗЗ-ийн арилжаа (их наяд төгрөгөөр)



## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Инновацийн тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 326 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 7. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
<b>Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч</b>		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	3
2	Үнэт цаасны клирингийн байгууллага	2 <sup>1</sup>
3	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн байгууллага	4
4	Үнэт цаасны төлбөрийн байгууллага	1 <sup>2</sup>
5	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	35
	Үнэт цаас итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх этгээд	2 <sup>3</sup>

<sup>1</sup> Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “ҮЦТХТ” ХХК орсон болно.

<sup>2</sup> “ҮЦТХТ” ХХК нь үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн болон төлбөрийн үйл ажиллагааг үзүүлдэг.

<sup>3</sup> Нэр бүхий 3 хөрөнгө оруулалтын менежментийн компани тус үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна /”Инвекор ассет менежмент” ХХК, “Балансэд грөүт менежмент” ХХК, “Үнэт ассет менежмент” ХХК /.

6	Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/	8
7	Үнэт цаасны компани	52
	Брокер	51
	Үүнээс:	
	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч	20
	Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч	22
	Үнэт цаасны номиналь дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэгч	3
	Дилер	34
	Андеррайтер	26 <sup>4</sup>
	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	25 <sup>5</sup>
8	Хөрөнгө итгэмжлэн удирдагч	5 <sup>6</sup>
9	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	2
10	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөлтэй компани	72 <sup>7</sup>
11	ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1
12	ХАА-н биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	9
13	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1 <sup>8</sup>
14	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/	14 <sup>9</sup>
15	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага	4
<b>Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд</b>		
16	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэгч байгууллага	76 <sup>10</sup>
	Аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	58
	Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага	25
17	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллага	50
<b>Нийт (ТЗ болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо)</b>		<b>326</b>

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 164 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ыг, 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.

*Хүснэгт 8. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ*

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нэр	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо	Зах зээлийн үнэлгээ 2025.III
---	-----------------------------------	------------------------------

<sup>4</sup> Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

<sup>5</sup> Нэр бүхий 4 хөрөнгө оруулалтын менежментийн компани тус үйл ажиллагааг давхар эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг /“Балансэд грөүт менежмент” ХХК, “Үнэт ассет менежмент” ХХК, “Блак свон” ХХК, “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК/ авсан.

<sup>6</sup> Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг барьцаат үнэт цаасны бүртгэлийг хянагчийн үйлчилгээ үзүүлэгч 1 хуулийн этгээд давхар эрхэлж байна.

<sup>7</sup> Тус тоонд “МИК ОССК” ХХК-39, “ҮЦСК” ХХК-5, “НОСК” ХК-5, нээлттэй хүрээнд ХБҮЦ гаргасан 22 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

<sup>8</sup> Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Монголын хөрөнгийн бирж” ХК орсон болно.

<sup>9</sup> Нэр бүхий 9 үнэт цаасны компани тус үйл ажиллагааг давхар эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг авсан.

<sup>10</sup> ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 7 компани байна.

1) “Монголын хөрөнгийн бирж” ХК -100 хувь төрийн өмчит -Төрийн өмчийн оролцоотой -Бусад	162 3 11 148	13,853,759,108,489.30 ₮ (Тус биржийн зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.)
2) “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК	2	25,681,353,795.00 ₮
3) “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК	-	-

### 3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид

2025 оны жилийн эцсийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл авсан 52 үнэт цаасны компани байгаагаас үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон бусад хавсран эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 51 үнэт цаасны компани байна. Үүнээс тайлант хугацаанд тайлан ирүүлсэн 51 үнэт цаасны компанийн нийт хөрөнгө 273.04 тэрбум, нийт орлого 44.24 тэрбум төгрөг байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

*Хүснэгт 9. Үнэт цаасны компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц*

Нийт хөрөнгө	Үнэт цаасны компаниудын тоо	Нийт орлого	Үнэт цаасны компаниудын тоо
< 100,000,000	6	< 100,000,000	35
100,000,000 - 1,000,000,000	18	100,000,000 - 1,000,000,000	6
1,000,000,000 <	27	1,000,000,000 <	11

2025 оны жилийн эцсийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл авсан 35 хөрөнгө оруулалтын менежментийн компани байна. Тус компаниудын хувьд 46 хувийн хөрөнгө оруулалтын сан, 8 хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр удирдан ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын нийт хөрөнгө 124.64 тэрбум, нийт орлого 2.55 тэрбум төгрөг байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

*Хүснэгт 10. Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц*

Нийт хөрөнгө	Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын тоо	Нийт орлого	Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын тоо
< 100,000,000	11	< 100,000,000	30
100,000,000 - 1,000,000,000	12	100,000,000 - 1,000,000,000	3
1,000,000,000 <	12	1,000,000,000 <	2

2025 оны жилийн эцсийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл авсан 8 хамтын хөрөнгө оруулалтын сан байгаагаас 5 нь хамтын нээлттэй, 2 нь хамтын хаалттай, 1 хамтын хаалттай биржээр арилжаалагдах сан хэлбэртэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд нийт хөрөнгө 202.17 тэрбум төгрөг байна. Харин Хороонд бүртгэлтэй 46 хувийн хөрөнгө оруулалтын сан байгаагаас тайлант хугацаанд тайлан ирүүлсэн 41 хувийн хөрөнгө оруулалтын сангийн нийт хөрөнгө 519.13 тэрбум төгрөг байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 11. Хөрөнгө оруулалтын сангуудын хөрөнгийн шатлалын бүтэц

Нийт хөрөнгө	Хамтын хөрөнгө оруулалтын сангуудын тоо	Хувийн хөрөнгө оруулалтын сангуудын тоо
< 100,000,000	-	19
100,000,000 -1,000,000,000	2	3
1,000,000,000 <	6	19

3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан


2025 оны жилийн эцсийн байдлаар Хороонд бүртгэлтэй номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч 22 компани байна. Тайлант хугацаанд тус 22 компанид бүртгэлтэй нийт 1,606,513 харилцагч байгаагаас 23,538 харилцагч үйлчилгээ авч, 739.64 тэрбум төгрөгийн болон 322.54 сая ам.долларын гүйлгээ хийсэн бөгөөд **Хавсралт 1**-ээс дэлгэрэнгүй тайланг үзнэ үү.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА

4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

График 14. ХААБ-ээр арилжаалагдсан түүхий эдийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 165 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 681 хэлцлээр нийт 1,039.63 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 4.73 хувиар өссөн үзүүлэлт юм.



Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны бүтэц




Нийт арилжааны дийлэнх хувийг буюу 91.66 хувийг ямааны ноолуур, 4.00 хувийг ямааны завод ноос, 0.94 хувийг хонины ноос, 1.44 хувийг тэмээний ноос, 0.96 хувийг тосны ургамал тус тус эзэлж байна.

#### 4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа


2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 369 удаагийн арилжаагаар 21.79 сая тонн нүүрсийг 5.58 их наяд төгрөгөөр, 224 удаагийн арилжаагаар 5.89 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 1.35 их наяд төгрөгөөр, 16 удаагийн арилжаагаар 51,545 тонн хайлуур жоншийг 51.90 тэрбум төгрөгөөр, 10 удаагийн арилжаагаар 50,000 тонн зэсийн баяжмалыг 376.35 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалж, нийт **619** удаагийн арилжаагаар **27.79** сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг **7.35** их наяд төгрөгөөр арилжаалсан ба өдрийн дундаж арилжаа **32.96** тэрбум төгрөгт хүрсэн байна.

График 16. Нийт арилжаалагдсан уул уурхайн биржийн бүтээгдэхүүний хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)



Нийт арилжаалагдсан бүтээгдэхүүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээгээр 11.97 хувиар өссөн, мөнгөн дүнгээр 17.36 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, өмнөх оны мөн үед нийт 571 удаагийн арилжаагаар 24.82 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 8.89 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.

График 17. Нийт арилжаалагдсан нүүрсний хэмжээ (төрөл, ангилал, хувиар)



Тайлант хугацаанд нийт 11 төрлийн 21.79 сая тонн нүүрс арилжаалагдсанаас 1/2 барьцалдах нүүрс 0.94 хувийг, 1/3 коксжих нүүрс 25.93 хувийг, баяжуулсан коксжих чанаргүй нүүрс 3.35 хувийг, баяжуулсан коксжих нүүрс 8.63 хувийг, баяжуулсан дунд зэрэг үнслэгтэй сул коксжих нүүрс 0.44 хувийг, баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс 6.17 хувийг, баяжуулсан сул коксжих нүүрс 4.43 хувийг, дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс 22.58 хувийг, эрчим хүчний нүүрс 25.61 хувийг, чийг багатай хүрэн нүүрс 1.44 хувийг тус тус эзэлж байна.

График 18. Нийт арилжаалагдсан төмрийн хэмжээ (төрөл, ангилал, хувиар)

Тайлант хугацаанд нийт 5.89 сая тонн төмрийн хүдэр, баяжмал арилжаалагдсанаас 21.05 хувийг Fe-52%-ийн агууламжтай төмрийн хүдэр, 72.29 хувийг Fe-58%-ийн агууламжтай төмрийн баяжмал, 0.45 хувийг Fe-62%-ийн агууламжтай төмрийн баяжмал, 6.21 хувийг Fe-65%-ийн агууламжтай төмрийн баяжмал тус тус бүрдүүлж байна.





График 19. Нийт арилжаалагдсан хайлуур жоншны хэмжээ (төрөл, ангилал, хувиар)



Тайлант хугацаанд нийт 5 төрлийн 51.55 мянган тонн хайлуур жонш арилжаалагдсанаас CaF2 <52% хайлуур жоншны хүдэр 3.03 хувийг, CaF2- <42% хайлуур жоншны хүдэр 6.68 хувийг, хайлуур жоншны баяжмал CaF2-95% 64.31 хувийг, CaF2<55% 6.68 хувийг, CaF2 97% хайлуур жоншны баяжмал 19.29 хувийг тус тус эзэлж байна.

## ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, тогтвортой ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

### 5.1. Эрх зүйн зохицуулалт

УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталсан.

Хууль батлагдсантай холбоотойгоор Хорооны зүгээс шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулахаар зохицуулсан холбогдох дүрэм, журмын төслийг боловсруулан шат дараатай батлуулан ажиллаж байна.



Тухайлбал, Хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор “Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журам”-ыг баталж, гарааны компани болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог хангах, бизнесийн орчныг дэмжих, харьцангуй найдвартай, хямд санхүүжилтийн эх үүсвэрийг богино хугацаанд, бага зардлаар татан төвлөрүүлэх зохицуулалтын орчин бүрдүүлээ.

Түүнчлэн, хөрөнгө оруулагчдын хувьд санхүүжилт татан төвлөрүүлж буй компанийн хувьцаа эзэмшигч болох, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох,

өгөөж хүртэх боломжтой болж, хөрөнгө оруулалтын сагсаа төрөлжүүлэх боломж нэмэгдэж байгаа юм.

Мөн мөнгөний зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болох банкнаас гаргах хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихтай холбоотой эрх зүйн зохицуулалтын орчин бий болсонтой холбогдуулан Хорооны 2025 оны 07 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам”-ыг баталсан. Ингэснээр иргэд, хадгаламж эзэмшигчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран банкаа сонгон хадгаламжид хөрөнгө оруулж, хадгаламжаа хоёрдогч зах дээр арилжаалах боломж бүрдэх бөгөөд үнэт цаасны зах зээлд хөрвөх чадвар сайтай хадгаламжийн сертификат бий болох эрх зүйн нарийвчилсан зохицуулалтын орчин бүрдлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хамтын хөрөнгө оруулалтын сангийн төрөл, сангийн хөрөнгө оруулалт хийх активын төрөл нэмэгдсэнээс гадна хувийн хөрөнгө оруулалтын санг гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах зохицуулалтын орчин бүрдсэн.

Энэ хүрээнд гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, гэрээнд тавих шаардлагыг тогтоохтой холбогдох харилцааг зохицуулахаар “Гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах

хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, Хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан бөгөөд тус журам батлагдсанаар дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь сайжирч, тэдгээрийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоо өсөж, дотоодын үнэт цаасны арилжаа, зах зээлийн үнэлгээ нэмэгдэн хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой.

Улсын Их Хурлаас Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар Монгол Улсад үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг зохицуулах эрх зүйн үндэс бүрдэж, зохицуулалтын орчныг бий болох боломж нээгдсэн. Үүний дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн бүх оролцогч талуудын оролцоог ханган өргөн хүрээтэй судалгаа, дүн шинжилгээг хийсний үндсэн дээр холбогдох журмыг олон улсын стандарт, шилдэг туршлагад нийцүүлэн боловсруулж, Хорооны 482 дугаар тогтоолоор “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай журам”-ыг баталснаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлд энэхүү шинэ үйлчилгээний зохицуулалтын орчныг бүрдүүллээ.

Олон улсын зах зээл дээр үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагаа нь хөрөнгийн зах зээлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж, зах зээлийн хөрвөх чадвар, идэвхийг нэмэгдүүлэх гол хэрэгсэл болж хөгжсөн байдаг бөгөөд үнэт цаас зээлэх, зээлдүүлэх эрх зүйн орчин бүрдсэн нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн дараагийн шат руу ахих чухал алхам болох ач холбогдолтой.



Үүний сацуу Хорооны зүгээс санхүүгийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиг үүргийн хүрээнд хүний эрхийг дээдэлсэн хүн төвтэй, хуулийн үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомжийг тодорхой ойлгомжтой болгож, хууль хүн бүрд ижил тэгш үйлчилдэг болгох, нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй ажилладаг болгох зэрэг чиглэлийг баримтлан ажиллаж, холбогдох дүрэм, журмуудыг хүчингүй болгон захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас хасуулах, шинээр батлах ажиллагааг хэрэгжүүллээ.

Тухайлбал, Хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”, 2022 оны 275 дугаар тогтоолоор баталсан ““Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”, 276 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг тус тус хүчингүй болгохоор шийдвэрлэж, Хорооны 2025 оны 60 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”, 64 дүгээр тогтоолоор “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны журам”, “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус баталсан.



Хорооны зүгээс ТОП-100 аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог өсгөх, биржийн болон биржийн бус зах зээлд нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд үнэт цаас гарган санхүүжилт татан төвлөрүүлэх байдлыг нэмэгдүүлэх хүрээнд тэдгээрийн бонд гаргах ажиллагаанд тавигдах шалгуурыг багасгаж, хялбар шуурхай байдлаар бүртгэх зорилгоор “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-уудад нэмэлт, өөрчлөлт оруулж, энэ оны 5 сард баталсан.

Тодруулбал, дээрх журмуудад ТОП-100 аж ахуйн нэгжээр шалгарсан компаниудад нийтэд санал болгон анх удаа хувьцаа /IPO/ гаргахад хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, нээлттэй болон хаалттай хүрээнд нэг жил хүртэлх хугацаатай 5 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий бонд гаргахад аливаа барьцаа, батлан даалт, андеррайтертай гэрээ байгуулахыг шаардахгүй байх, мөн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгүүлэх тухай хүсэлтийг СЗХ бүртгэх эсэх шийдвэрийг ажлын 10 хоногийн дотор гаргах зэрэг зохицуулалтуудыг тусгасан.

Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулснаар дотоодын томоохон компаниудад хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд үнэт цаас гаргах замаар санхүүжилт татах зохицуулалтын таатай орчин бүрдэхийн зэрэгцээ үйл

ажиллагаагаа өргөжүүлэх, ашигт ажиллагаа, нэр хүнд, засаглал нь өсөх, улмаар гадаад, дотоодын зах зээлээс дахин санхүүжилт татахад давуу тал үүсэж, хөрөнгийн зах зээлийн хөгжил болон эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Тус Хорооны зүгээс “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д нийгмийн бонд болон тогтвортой байдлын бонд гаргахтай холбоотой зохицуулалтын нэмэлт, өөрчлөлтийг Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо /International Capital Market Association/-оос гаргасан нийгмийн, тогтвортой байдлын бондын стандарт зарчмуудад нийцүүлэн баталж, тогтвортой хөгжлийг дэмжих эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүллээ.

Үүний үр дүнд Монгол Улсад ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх, байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн шинэ санхүүгийн бүтээгдэхүүний төрөл тоо нэмэгдэж, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх оролцоо нэмэгдэх зэргээр дотоодын бондын зах зээлийг хөгжүүлэхэд чухал ач нөлөө үзүүлэх юм.



Биржийн бус зах зээлийн арилжааны төлбөр тооцоо түргэн, шуурхай хийгдэх, мөн өдрийн зургаан цагаар хязгаарлагддаг байсан арилжааг 24/5 тасралтгүй явуулах, хөрөнгө оруулагчдад бодит цагийн, ил тод, нээлттэй орчныг бий болголоо. Ингэснээр Монгол Улс

энэхүү шийдлийг нэвтрүүлсэн дэлхийд анхдагч орнуудын нэг болж байна.

## 5.2.Хамтын ажиллагаа, арга хэмжээ

Олон улсад тогтвортой, ногоон хөгжил рүү шилжих шинэ хандлагыг даган компаниуд зөвхөн хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг бий болгоход бус урт хугацааны үнэ цэн, тогтвортой өсөлтийг чухалчлах болсон нь тогтвортой байдлын хүчин зүйлс нь санхүүгийн шийдвэр гаргах чухал бүрэлдэхүүн хэсэг болсныг харуулж байна. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс тогтвортой ногоон санхүүжилтийг тогтолцоог бий болгоход онцгой анхаарч ажиллаж байна.

Тухайлбал, Испанийн засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Үндэсний Санхүүжилтийн Нэгдсэн Тогтолцоо (INFF)-оос хамтран “Түншүүд хоорондын уулзалт”-ын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан “Тогтвортой хөгжлийн зорилт ба сэдэвчилсэн бонд” сэдэвт хэлэлцүүлэгт Хорооны төлөөлөл оролцож, ногоон, тогтвортой санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн стратегиуд болон ногоон бонд, тогтвортой хөгжлийн зорилтуудтай холбоотой санаачилгуудаа танилцууллаа.



Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлага, тогтвортой байдлыг бэхжүүлэх мөн байгаль орчинд ээлтэй

төсөл, хөтөлбөрийг дэмжих замаар тогтвортой, ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-тай хамтын ажиллагааны санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. Энэхүү санамж бичгийг үзэглэж “Ногоон санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх” төслийн хоёрдугаар үе шатыг албан ёсоор эхлүүлснээр дотоодын компаниудад ногоон бондоос гадна усны экосистем, био олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, гол мөрөн, усны ай савыг хамгаалах, нөхөн сэргээх бонд, байгаль орчин болон нийгэмд чиглэсэн тогтвортой хөгжлийн дэмжих бонд мөн тогтвортой хөгжлийн тодорхой зорилтод чиглэсэн хүрэх үр дүн тодорхой бонд, зорилгоо биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд бондын хүүгээ нэмэх, нэмэлт төлбөр өгөх зэргээр санхүүгийн хариуцлага хүлээдэг бонд зэрэг тогтвортой санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлнэ. Ингэснээр байгаль орчинд ээлтэй санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж хөрөнгө оруулалт татах таатай нөхцөлийг бүрдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг нь төрөлжүүлэх боломж бүрдэж байна. Тодруулбал, олон улсын стандартад нийцсэн, илүү уян хатан, байгаль орчинд ээлтэй санхүүгийн тогтолцоог хөгжүүлж, манай улсын санхүүгийн салбарын хөгжилд бодит хувь нэмэр оруулах эхлэл тавигдаж байна.



Мөн Хорооны зүгээс Сангийн яам, Монголбанк, Солонгосын Санхүүгийн үйлчилгээний хороо (KFSC), Солонгосын Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны зөвлөл (CIFC)-тэй хамтран “Солонгос-Монголын санхүүгийн хамтын ажиллагааны форум”-ыг амжилттай зохион байгууллаа. Форумын үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлага, сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн бодлогын гол арга хэмжээний талаар дэлгэрэнгүй танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар холбогдох талуудтай санал солилцов. Мөн энэхүү форум нь Монгол, Солонгосын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойтой давхцаж буйгаараа онцлог болсон бөгөөд хоёр улсын санхүү, хөрөнгийн зах зээлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага солилцох, шинэ боломжуудыг тодорхойлох чухал алхам боллоо.



Түүнчлэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц БНСУ-ын Үнэт цаасны санхүүжилтийн корпорац (Korea Securities Finance Corporation)-ын ерөнхийлөгч Ким Жонг-Гак нар өнөөдөр хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэлээ. Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой зохицуулалтын орчныг бий болгохоор ажиллаж байгаа бөгөөд уг

санамж бичгийг байгуулснаар тус корпорацтай дээрх чиглэлд үе шаттайгаар хамтын ажиллагааг эхлүүлэх, техник, эдийн засгийн зөвлөгөө, дэмжлэг авах боломж бүрдлээ. Энэхүү зохицуулалтын орчныг бүрдүүлснээр хөрөнгийн зах зээлийг төрөлжүүлж, арилжааны идэвх, хөрвөх чадвар нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлэх болно.



Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан тэргүүтэй айлчлалын бүрэлдэхүүн 09 дүгээр сарын 4-7-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан Улсад ажиллав. Энэхүү айлчлалын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Астанагийн санхүүгийн үйлчилгээний байгууллага болох “Astana Financial Services Authority”-ын дарга Евгения Богданова нар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа.

Санамж бичиг байгуулснаар хоёр байгууллага хил дамнасан санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл солилцож, финтект суурилсан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлдэг компаниудад чиглэсэн техник хамтын ажиллагаа явуулна. Мөн хөрөнгийн зах зээл, даатгал, финтек салбарын байгууллагуудын аюулгүй, найдвартай үйл ажиллагааг дэмжих хүрээнд санхүүгийн хяналт шалгалт хийхэд харилцан туслалцах, хоёр байгууллагын чадавхыг бэхжүүлэх чиглэлд хамтран ажиллах юм.

Азийн үнэт цаасны холбоодын 30 дахь удаагийн форумыг МҮЦАЭХ-той хамтран зохион байгуулсан бөгөөд Ази-Номхон далайн бүсийн үнэт цаасны салбарын хамгийн нэр хүндтэй форумд 20 гаруй орны 100 гаруй хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүд оролцож хөрөнгийн зах зээлийн хөгжлийн чиг хандлага, цаашдын хамтын ажиллагаа болон тогтвортой санхүүжилт, дижитал шилжилт, бүс нутгийн интеграц, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хэрхэн хамгаалах талаар хэлэлцэв.

Азийн 20 гаруй орны 24 мянга гаруй хөрөнгө оруулагчийг эгнээндээ нэгтгэдэг Азийн үнэт цаасны холбооноос зохион байгуулж буй энэ удаагийн форум манай улсад анх удаа зохион байгуулагдсан нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил бүс нутгийн төвшинд амжилттай хөгжиж байгаагийн нэг илрэл юм. Нөгөө талаар Монголын хөрөнгийн зах зээл, онцлох төсөл, оролцогч талуудыг олон улсын тавцанд илүү өргөн хүрээнд таниулах түүхэн ач холбогдолтой үйл явдал боллоо.



Тус форумын үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын санхүүгийн төвүүдтэй холбох, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг нээх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор зохион байгуулж буй “Mongolia’s Capital Market Connectivity

2025” арга хэмжээ Улаанбаатар хотноо анх удаа зохион байгуулагдав.

Арга хэмжээний үеэр Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлагын талаар танилцуулсны зэрэгцээ уул уурхайн олон улсын хөрөнгө оруулалт, хөрөнгө босгох стратеги, банкны үйл ажиллагаа ба санхүүжилтийн шинэ гарцууд, Ази, Европ болон бусад бүс нутгийн хөрөнгө оруулагчидтай хил дамнасан хамтын ажиллагааны талаар хэлэлцүүлсэн юм.

Монгол Улс, Япон Улсын төр, хувийн хэвшлийн төлөөллийн хамтарсан 12 дахь удаагийн зөвлөлдөх уулзалт Токио хотноо амжилттай зохион байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц оролцож, Монгол Улсын санхүүгийн салбарын эрх зүйн шинэчлэл, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалтын орчны сайжруулалт, ногоон санхүүжилтийн талаар танилцууллаа.

Тус зөвлөлдөх уулзалтын хүрээнд хоёр улсын санхүү, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, Японы хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилготой “Монголын өдөр” хөрөнгө оруулалтын форумыг зохион байгуулсан бөгөөд хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэл”-ийн хүрээнд санхүүгийн салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, хөрөнгө оруулалтын шинэ чиглэл болон бодит боломжуудыг нээх чухал ач холбогдолтой болов. Мөн төр, хувийн хэвшлийн түншлэл, хөгжлийн хамтын ажиллагааны төсөл, арга хэмжээг өргөжүүлэхэд чиглэгдэв.

Япон Улс нь Монгол Улсын хамгийн том донор орон бөгөөд энэхүү уулзалт, форум нь манай улсын санхүүгийн тогтолцоог олон улсад таниулах,

гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хоёр улсын стратегийн түншлэлийг улам бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.



Мөн форумын үеэр тус Хорооны дарга Япон Улсад ажиллаж, амьдарч буй монгол иргэдтэй уулзаж, Монгол Улсын эдийн засгийн бодлого, санхүүгийн зах зээлийн шинэчлэл, хөрөнгийн зах зээлийн боломж болон гадаад мөнгөн

гуйвуулгын үйлчилгээг сайжруулахтай холбоотой мэдээлэл өгч, иргэдийн асуултад хариулт өгсөн.

Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл “Сингапурын финтек фестиваль 2025”-д оролцож, “Блокчейн технологид суурилсан биржийн бус зах зээлийн арилжаа, төлбөр тооцооны шинэчлэл” сэдвээр илтгэл тавилаа. Тухайлбал, Монгол Улсын биржийн бус зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог блокчейн технологид бүрэн шилжүүлсэн шинэчлэлийн талаар танилцуулж, шийдлийн зорилго, тулгарсан сорилт, туршилтын үе шат болон хүрсэн бодит үр дүнгийн талаар мэдээлэл өгч, олон улсын хөрөнгө оруулагчдад дотоодын хөрөнгийн зах зээлийн ахиц дэвшлийг танилцууллаа.

## ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

---o-0-o---

**Хавсралт 1. Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэгчдийн тайлан**

№	Компанийн нэр	Нийт харилцагчдын тоо		Үйлчилгээ авсан харилцагчдын тоо	Нийт авсан/ зарсан гүйлгээ	Эцсийн үлдэгдэл
		\$	₮			
1	“Бидисек ҮЦК” ХК	\$	63	1	699,821.68	1,706.45
		₮	7,185	1,266	41,800,145,975.39	2,152,286,134.70
2	“Мирэ эссет секьюритис монгол ҮЦК” ХХК	₮	10,645	27	2,968,769,426.11	96,373,146.82
		\$	162	6	303,166,255.24	44,825.30
3	“Ард секьюритиз ҮЦК” ХХК	₮	167,993	4,730	12,790,803,445.12	1,208,097,363.36
4	“Гүүдсек ҮЦК” ХХК	₮	755,449	614	2,456,681,431.59	183,353,672.77
		\$	21	0	0.00	47.72
5	“Райнос инвестмент ҮЦК” ХХК	₮	8,940	75	4,301,831,122.69	258,157,661.67
		\$	80	7	49,949.08	1,745.42
6	“Эс Жи Капитал ҮЦК” ХХК	₮	9,958	2,032	14,478,863,951.73	612,145,798.60
7	“ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК” ХХК	₮	57,495	1,311	51,568,423,496.87	3,722,925,218.72
		\$	397	56	3,535,070.92	90,715.63
8	“Голомт капитал ҮЦК” ХХК	₮	81,419	4,526	228,222,309,748.05	7,826,868,414.87
		\$	28	1	2,018,417.77	274.29
9	“Өлзий энд КО капитал ҮЦК” ХХК	₮	45,580	804	7,681,635,185.81	527,559,821.77
10	“Алекс капитал ҮЦК” ХХК	₮	38,961	1,564	35,323,189,946.69	3,155,903,098.32
		\$	0	0	0.00	230.71
11	“Инвескор капитал ҮЦК” ХХК	₮	12,524	330	179,106,403,342.92	1,051,169,890.92
		\$	20	8	1,799,173.15	55,383.01
12	“Нэйшнлсэжуритис ҮЦК” ХХК	₮	12,985	21	20,404,045.87	22,150,355.27
13	“Таван богд капитал ҮЦК” ХХК	₮	63,034	714	6,830,037,095.78	918,623,528.10
		\$	851	223	5,708,317.81	1,815,627.73
14	“Мандал капитал маркетс ҮЦК” ХХК	₮	19,060	1,263	18,866,168,099.24	451,689,241.27
		\$	19,060	28	5,567,769.82	57,957.99
15	“Новел-Инвестмент ҮЦК” ХХК	₮	34,244	81	964,094,197.19	120,967,773.96
16	“Эс Жи инвестмент энд секьюритис ҮЦК” ХХК	₮	8,588	681	498,068,313.22	14,266,965.72
		\$	0	0	24.96	26,745.21

17	“Стандарт-Инвестмент ҮЦК” ХХК	₮	1,102	161	16,975,698,626.14	2,276,176,880.43
18	“Стоклаб секьюритиз ҮЦК” ХХК	₮	44,152	2,859	1,255,566,568.92	19,053,462.86
19	“Тэнгэр капитал ҮЦК” ХХК	₮	444	55	113,314,473,633.94	267,711,721.90
20	“Ди Си Эф ҮЦК” ХХК	₮	4,901	1	11,808.97	245,408.03
21	“Монсек ҮЦК” ХХК	₮	157,682	66	176,924,411.89	1,923,083.93
22	“Алтанхоромсог ҮЦК” ХХК	₮	43,490	27	37,599,836.64	4,763,521.59
НИЙТ		₮	<b>1,585,831.00</b>	<b>23,208.00</b>	<b>739,638,103,710.77</b>	<b>24,892,412,165.58</b>
		\$	<b>20,682.00</b>	<b>330.00</b>	<b>322,544,800.43</b>	<b>2,095,259.46</b>